

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН СТАНДАРТЧИЛАЛ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ТУШААЛД ТОМИЛОГДОХ АЖИЛТНЫ СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗАРЛАЖ БАЙНА**

Нэг. Сонгон шалгаруулалтын зорилго

Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газрын Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын даргын сул орон тоог төрийн жинхэнэ албан тушаалд ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар болон тусгай шаардлагыг хангасан, тус газарт ажиллаж байгаа албан хаагчдаас шалгаруулна.

Хоёр. Сонгон шалгаруулалтын бүртгэл

Зарлаж буй сул орон тоонд **боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар** ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан тус газарт ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдын материалыг төв байрны 203 “Б” тоот өрөөнд ажлын хэсэг **2016 оны 11 дүгээр сарын 21-ээс 23-ны өдрүүдэд 09.30-11.30, 15.00-16.30** цагийн хооронд хүлээн авна.

Гурав. Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн албан хаагчид дор дурдсан материалыг бүрдүүлэн өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.

- Үүнд:
1. Төрийн албан хаагчийн анкет (маягт № 1);
 2. Боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
 3. Монгол Улсын иргэний үнэмлэх; /нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/;
 4. Ажилласан жилийг тооцох Хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн эхний нүүр хуудсыг хөдөлмөрийн үйл ажиллагааны хөдөлгөөнийг баталгаажуулсан бусад хуудасны хуулбар, эх хувийн хамт. /ажилласан жилийг тооцох тул хөдөлмөрийн үйл ажиллагаагаа хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтэрт бичигдсэн он, сар, өдрөөр нь нарийвчлан бичиж бэлтгэж ирэх/
 5. Төрийн албан хаагчийн тангараг өргөсөн хуудас
 6. Тухайн албан тушаалд томилогдсон тушаалын хуулбар
 7. Сүүлийн 2 жилийн үр дүнгийн гэрээний илтгэх хуудас

Тамгын газар

В. ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Ажлын байранд тавигдах шаардлага	1.1. Ерөнхий шаардлага:	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Дээд боловсролын бакалавр зэрэгтэй	Дээд боловсролын бакалавр зэрэгтэй
		Мэргэжил	Эрх зүйч, инженерчлэл.	Байгалийн болон техникийн шинжлэх ухааны чиглэл,
		Мэргэшил	“Төрийн удирдлага”, “Захиргааны эрх зүй”, “Стандартчилал, техникийн зохицуулалт, Тохирлын үнэлгээ”-ний чиглэлээр мэргэшсэн байх	Стандартчилал, техникийн зохицуулалт, Тохирлын үнэлгээ”-ний чиглэлээр мэргэшсэн байх
		Туршлага	Төрийн албанд 5-аас доошгүй жил ажилласан, тус салбарт 3-аас доошгүй жил ажилласан, салбарын ажлын дадлага туршлагатай. Удирдах албан тушаалд ажиллаж байсан бол давуу тал болно.	Төрийн албанд 5-аас доошгүй жил ажилласан, Удирдан манлайлах чадвартай,
		Ур чадвар	-Удирдан зохион байгуулах, -Багаар ажиллах, баг бүрдүүлэх ур чадвартай, -Бодлогын баримт бичиг боловсруулах чадвартай -Компьютерийн өргөн хэрэглээний программуудыг бүрэн эзэмшсэн, Гадаад хэлний зохих мэдлэгтэй -Монгол хэлний найруулга зүй, нэр томъёо, хэллэг төгс эзэмшсэн байх,	-Эрх мэдлийнхээ хүрээнд бусдад нөлөөлөх, -Нийтийн зорилгод тууштай байх, -Менеджментийн онолын мэдлэг, практик туршлагатай, -Хамт олныг удирдан шинэчлэлтийг манлайлах, -Үр дүнд чиглэн ажиллах, -гадаад хэлний мэдлэгтэй,
	1.2. Тусгай шаардлага:		- Манлайлах, удирдан зохион байгуулах; - Илтгэх, оновчтой шийдвэр гаргах; - Хууль тогтоомжийг сахих, мөрдөх, өндөр ёс суртахуунтай байх; - Нууцыг хадгалах; - Ажлын ачаалал даах оюуны болон бие бялдарын чадавхитай байх.	